

**УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 05 ДУГЭЭР САРЫН 15-НЫ ӨДРИЙН
ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨНӨӨС ӨГСӨН ҮҮРГИЙН БИЕЛЭЛТ**

2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр

№	Өгөгдсөн үүрэг, даалгавар	Хэрэгжүүлэх хугацаа	Хэрэгжүүлэх байгууллага	Биелэлт	хувь
1.	Өрхийн эмнэлэгт ашиглагдаж байгаа автомашины судалгаа гаргах, Өрхийн эрүүл мэндийн төвийн байруудыг эрүүл мэндийн стандартад нийцүүлэн засварлах шинэчлэх, дэд бүтцэд холбох ажилд дэмжлэг үзүүлэн хэрэгжилтийг хангуулах	2023 оны 05 дугаар сарын 29	НБХ ЭМГ Сумдын Засаг дарга нар	Энхтусдэм ӨЭМТөвд Тоёота виш автомашин – 1, Шивээговь сумын ЭМТөвд Пургон – 1, Баянтал сумын ЭМТөвд Пургон – 1, Тоёота Клүгэр Автомашин – 1 нийт анхан шатны эрүүл мэндийн 3 байгууллагад 4 машин ашиглагдаж байна. 2 сумын эрүүл мэндийн төв нь стандарт шаардлагад нийцсэн байртай болсон. Харин “Энхтус дэм” өрхийн эрүүл мэндийн төвийн шинэ барилга барих газрын асуудлыг шийдвэрлэж, барилгын ажлын зураг төсөв хийлгэх төсвийг 2024 оны аймгийн ОНХС-ийн 20 сая төгрөгийн хөрөнгөөр хийлгэхээр батлуулсан.	70
2.	Түр оршин суугчдын судалгаа гарган эрт илрүүлэгт хамруулах, цаашид анхан шатны тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлж байх.	2023 оны 05 дугаар сарын 29	НБХ ЭМГ Сумдын Засаг дарга нар	Говьсүмбэр аймагт түр оршин сууж байгаа иргэдийн судалгааг нэгтгэхэд Сүмбэр суманд – 665, Шивээговь суманд – 236, Баянтал суманд - 133 нийт 1034 иргэн түр оршин сууж байна. Говьсүмбэр аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагууд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг харьяалал харгалзахгүй үзүүлж байна. 2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар харьяалалын бус 1876 иргэнд төрийн үйлчилгээ үзүүлсэн байна.	100
3.	Багийн хүн амын тоо, нэг өрхийн эмчид ногдох өвчтөний тооны харьцаа стандартад нийцэж байгаа эсэх, хэрхэн зохицуулах талаар танилцуулах.	2023 оны 05 дугаар сарын 29	НБХ ЭМГ Сумдын Засаг дарга нар	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/212 тоот тушаалаар батлагдсан Өрхийн эрүүл мэндийн төвийн үлгэрчилсэн дүрмийн 1.7 дахь заалтад өрхийн эрүүл мэндийн төвд ноогдох иргэний доод хязгаар нь аймаг орон нутагт 6000-аас доошгүй байна. Өрхийн Эрүүл мэндийн төвийн бүтэц үйл ажиллагааны стандартад зааснаар 1800- 2000 хүн тутамд нэг их эмч ажиллана гэж заасан байдаг.	50

				Эдгээр эрх зүйн актуудад зааснаар авч үзвэл нэг эмчид ногдох хүн амын тоо 1800-2000 байх ёстой байтал одоогоор 3250 байгаа нь өрхийн эрүүл мэндийн төвийн ачаалал 2 дахин нэмэгдэж, хүн амд үзүүлэх анхан шатны эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж буурч байгаа харагдаж байна.	
4.	Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх мод тарилтын ажлыг эрчимжүүлэхэд байгууллагууд идэвхтэй оролцох.	2023 оны 05 дугаар сарын 29	Бүх байгууллага	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд бүх нийтээр мод тарих ажлыг 05-р сарын 08-ны өдөр зохион байгуулж 33 төрийн байгууллага, 19 хувийн хэвшлийн байгууллага, 650 албан хаагч, 220 иргэн, нийт 25000 мод тарьсан байна.	100
5.	Малын цэцэг өвчин гарсантай холбоотойгоор Төмөр замын “Лүн зөрлөг”-ийн нүхэн гарцыг түр хугацаагаар хаах ажилд дэмжлэг үзүүлж, хамтарч ажиллах.	2023 оны 05 дугаар сарын 29	Чойр өртөө, Сүмбэр сумын Засаг дарга	Цэцэг өвчний голомтын бүсрүү мал оруулахгүй байх зорилгоор 608, 613, 628, 633 км-т байрлах нүхэн гарцуудыг хаасан.	100
Биелэлтийн дундаж хувь					84%

Үүргийн биелэлт нэгтгэж, үнэлсэн:ХШҮ-ний хэлтсийн мэргэжилтэн

Б.Мөнхзаяа